



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 2/395

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 23 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлбөрийн орлогыг ашиглах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.1945 оны чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин Арвайхээр сумын харьяат Гачингийн Зундуйдамба, Хархорин сумын харьяат Дамдинсүрэнгийн Нямаа нарт тус бүр 500,000 төгрөг, нийт 1,000,000 төгрөгийг нэг удаагийн буцалтгүй тусламжаар, цэргийн штаб үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зардалд 850,000 төгрөг, нийт 1,850,000 (нэг сая найман зуун тавин мянган) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлбөрийн орон нутагт үлдэх орлогоос зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100862